

“ЭМТ ТАВАН РАШААН”-НЫ НАЙРЛАГА БА ДЭВТЭЭЛГЭ ЗАСЛЫН ХЭРЭГЛЭЭ*Chen Liang¹, Нарангэрэл Зулцэцэг^{2*}, Зундуй Ариунаа²**¹Үндэстний Их Сургуулийн Хараат Эмнэлгийн Хороо,
Өвөр Монголын Өөртөө Засах Орон, БНХАУ**²Сургалтын Бодлого, Зохицуулалтын Алба, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль,
Улаанбаатар, Монгол Улс***цахим хаяг: zultsetseg@monos.mn***“COMPOSITION OF ‘EMT TAVAN RASHAAN’ AND ITS THERAPEUTIC APPLICATION IN BALNEOTHERAPY”***Chen Liang¹, Zultsetseg Narangere^{2*}, Ariunaa Zundui²**¹Affiliated Hospital of Inner Mongolia University for the Nationalities,
Inner Mongolia Autonomous Region, China**²Office of Academic Policy and Coordination, Mongolian University of Pharmaceutical Sciences,
Ulaanbaatar, Mongolia***email: zultsetseg@monos.mn***Abstract:**

The Five Medicinal Essences (“Ganlu”) are traditionally described in Mongolian medicine as five sacred, sweet elixirs believed to promote health and longevity. This concept is incorporated into the theoretical framework of traditional fomentation therapy, which aims to restore balance among physiological functions, mental state, and internal energy. The formulation consists of five plant materials: *Ledum palustre* L., *Juniperus dahurica* Pall., *Myricaria longifolia* (Willd.) Ehrenb., *Ephedra przewalskii* Stapf, and *Artemisia frigida* Willd., combined in a ratio of 1:1:2:2:3. The herbal materials are prepared as a decoction and administered as a medicinal extract for external therapeutic application in balneotherapy.

Traditionally, this formulation has been used in Mongolian and integrative medical practice for the management of rheumatic joint disorders, ankylosis, spondylitis, brucellosis, postpartum wind-related disorders, dermatological diseases—particularly psoriasis—and neurological conditions such as hemiplegia and paralysis. Reported therapeutic effects include improvement of blood circulation, modulation of physiological functions, stimulation of metabolic processes, promotion of detoxification, muscle relaxation, and relief of localized pain. However, the therapy is contraindicated in patients with acute infectious diseases (e.g., typhoid fever), severe systemic debilitation, purulent or inflammatory conditions, necrotizing processes, stage II–III hypertension, malignant neoplasms, or venous thrombosis. Further pharmacological and clinical investigations are necessary to clarify the mechanisms of action of the constituent plants and to provide scientific evidence supporting the integration of this traditional formulation into modern healthcare practice.

Five Medicinal Essences, traditional fomentation therapy, plant-based formulation, rheumatic disorders.

Үндэслэл

Уламжлалт анагаах ухаанд дэвтээлгэ заслын эмчилгээ чухал байр суурь эзэлдэг. Дэвтээлгэ гэдэг нь байгалийн болон уламжлалт эмийн найрлагаар бэлтгэсэн рашаанд өвчтөнийг оруулах замаар хэрэглэх зөөлөн, аюул багатай эмчилгээний арга юм. Энэ нь төрөл, хэрэглэх арга, эмийн түүхий эдээрээ

ялгаатай олон хэлбэртэй байдаг. Тодруулбал: байгалийн рашаан, таван найрлагат рашаан, ясан дэвтээлгэ, сэвсэн дэвтээлгэ, арьсан дэвтээлгэ, ууран дэвтээлгэ, ороох дэвтээлгэ, тухайлсан эмийн дэвтээлгэ, бүтэн биеийн дэвтээлгэ, хэсэг газрын дэвтээлгэ гэх мэт олон төрөл бий.

Дэвтээлгэ нь өвчний хор уршгийг шар усны

нүхээр гадагшлуулж, хийг дарж, хавдрыг бууруулахад хувь нэмэр оруулдаг. Мөн цус, энергийн гүйдлийг сайжруулах, бие махбодийн үйл ажиллагааг тэнцвэржүүлэх, бодисын солилцоог эрчимжүүлэх, хордлогыг тайлах, булчинг сулруулах, хэсэг газрын өвдөлтийг намдаах зэрэг олон талт ач холбогдолтой.

Дэвтээлгийг шар усны өвчин, үе мөч хөшиж атирах, тахийх, эмэгтэйн хий бүрэлдсэн өвчин, нуруу бөгтөр болох, яс маханд шар ус хуримтлагдсан, хий өвчнүүд, гадар цагаан судасны өвчин зэрэгт хэрэглэхийг зөвлөдөг. Харин хижиг, хэт халуун эсвэл тархсан халуун, цайвар хаван, тамир доройтсон, идээт, халдварт, үхжилт үрэвсэл, артерийн даралт ихсэлтийн II–III зэрэг, хорт хавдар, венийн тромбоз зэрэгт хэрэглэхийг хориглодог.

Гүн ухааны үзлээр, эмт таван рашааныг (“Ганлу”) таван төрлийн амтат ариун ундаа буюу бурханлаг шимт ундаа хэмээн нэрлэдэг. “Ганлу” гэдэг нь амрит, шимт ундаа, урт насны рашаан гэсэн утгатай бөгөөд хүний биеийг эрүүлжүүлэх, урт наслахад тустай хэмээн үздэг.

Буддын ухаанаар “Таван амтны ганлу” буюу “Эмт таван рашаан” нь бие, хэл, сэтгэлийн бохирдлыг ариусгах, урт наслах, ивээл хангуулах, амгалан тайван байдал авчрах утгатай билэгдлээр илэрхийлэгддэг. Энэ үзэл нь уламжлалт дэвтээлгэ заслын философитой уялдан хүний бие махбод, сэтгэл оюун, энергийн гүйдлийг эрүүлжүүлэх эмчилгээний ач холбогдлыг тодорхойлон харуулдаг.

1. Чихэрлэг амт (甘) - Элсэн чихэр мэт амттай, зөөлөн, амгаланг төлөөлнө.

2. Исгэлэн амт (酸) - Хүчтэй, сэргээх чанартай, бясалгалын хурцыг бэлгэднэ.

3. Гашуун амт (苦) - Тэвчээр, саад бэрхшээл давах чанарыг илтгэнэ.

4. Халуун амт (辛) - Шаргуу хөдөлмөр ба ариуслыг бэлгэднэ.

5. Давслаг амт (鹹) - Амьдралын олон талт байдлыг илтгэх, тэнцвэрийг бэлгэддэг.

Эмт таван рашаанаар эмчлэх боломжтой өвчний дотор хайрст үлд буюу псориаз өвчин багтдаг.

Судлагдсан байдал

Уламжлалт анагаах ухаанд дэвтээлгэ заслын арга чухал байр суурь эзэлдэг. Энэхүү арга нь шар усны өвчний урхагийг хөлс болгон гадагшлуулж, хийг дарж, хавдрыг багасгах, цус болон хийн эргэлтийг сайжруулах, бодисын солилцоог идэвхжүүлэх, бие махбодийг тэнцвэржүүлэх зэрэг олон талын үйлдэлтэй.

Эмт таван рашаан буюу “Таван амтны ганлу” нь бие, хэл, сэтгэлийн бохирдлыг ариусгах, урт нас, ивээл, амгалан авчрах бэлгэдэлтэй хэмээн Буддын ухаанд тайлбарлагддаг талаар Buswell., Robert E болон Lopez (2013) нар тэмдэглэн үлдээжээ.

Уламжлалт анагаах ухаанд энэхүү рашаанаар шар усны өвчин, үе мөч хөшиж атирах, эмэгтэйн хий бүрэлдсэн өвчин, нуруу болон яс махны эмгэг, гадар судсыг өвчлөх зэрэгт дэвтээлгэ хийхийг зөвлөдөг бөгөөд халдварт өвчин, идээт үрэвсэл, хорт хавдар, венийн тромбоз, артерийн даралт өндөр үед эсрэг заалттай байдаг.

Өрнийн анагаах ухаанд хайрст үлд (psoriasis) нь улаан өнгийн тодорхой товруун дээр мөнгөлөг цагаан хайрсаар хучигдсан, архаг явцтай өвчин юм. Энгийн хэлбэрийн хайрст үлд нийт тохиолдлын 99%-ийг эзэлдэг ба насанд хүрэгчдийн дунд 0.51–11.43%, хүүхдэд 0–1.37% тархдаг.

Псориаз нь дэлхийн хэмжээнд нийт хүнамын 2-4%-д тохиолддог бөгөөд өвчний давтамж нас, хүйс, бүс нутгийн хувьд ялгаатай болохыг Parisi R, Symmons DP болон Griffiths CE (2013) нар судлан тогтоожээ. Харин Huerta C, Rivero E болон Garcia Rodriguez LA нар “Псориазын

эрсдэлт хүчин зүйлд удамшил, архаг стресс, таргалалт, зарим эмийн зохисгүй хэрэглээ орох бөгөөд жилд 2-3 хүн тутамд тохиолдох эрсдэлтэй” хэмээжээ.

Эрдэмтэн Griffiths CE, Barker JN (2007) нарын судалснаар Псориаз нь дархлааны хэт идэвхжилтэй үрэвсэлт өвчин бөгөөд арьсны эпидермисийн эсийн давшингүй өсөлтөөр илэрч, артритээр хүндэрдэг болохыг тогтоожээ.

Хятад улсад тархалт 0.47% бөгөөд жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байгаа мэдээлэл байна.

Өвчин нь бие махбод, сэтгэл зүйд нөлөөлж, нийгмийн амьдрал, амьдралын чанарт сөрөг нөлөө үзүүлдэг. Үүсэх шалтгаан нь бүрэн тодорхойгүй ч удамшил, дархлаа, орчны хүчин зүйл, стресс, халдвар, эмийн нөлөөгөөр үүсдэг гэж үздэг.

Хайрст үлд өвчний үед шинж тэмдэг тодорхой илэрдэг.

1. Тархалт: Тууралт биеийн аль ч хэсэгт үүсэх боломжтой боловч мөчдийн сунгалтын гадаргуу болон нуруу-бэлхүүсийн бүсэд хамгийн түгээмэл байрлана. Ихэнх тохиолдолд илрэл симметрик байдаг. Толгойн хуйх оролцвол үс бөөгнөрч багцлагдах (tufted hair) шинж илрэх боломжтой. Хумсны оролцоотой үед питтинг (pitting), үүнд хумсан дээр жижиг нүхэрхүү хонхор үүсэх шинж тэмдэг ажиглагдана.

2. Арьсны өөрчлөлт: Тод хязгаартай, улаан өнгийн папул эсвэл макуло-папулын тууралт үүсч, дээр нь олон давхар, хуурай, мөнгөлөг-цагаан хайрс бүрхсэн байна. Хайрсыг зөөлөн хусаж авахад лав дуслын шинж, улмаар тунгалаг хальсны шинж илэрч, зарим тохиолдолд цэгэн цусархагжил (Auspitz-ийн шинж) ажиглагдана.

3. Морфологи: Тууралт нь дусал, товруу, зоосон хэлбэртэй, географик зураглалтай эсвэл хясаа-давхраат (oyster-shell) дүрстэй төрөл бүрийн хэлбэртэй байж болно.

4. Шинж тэмдэг: Хайрст үлдний арьсны гэмтэл нь товруу эсвэл зангилаа, хайрсжилт, хальс үүсэх үзэгдэл, цэгэн цусархагжил (Auspitz-ийн шинж)-ээр илэрдэг. Өвчин нь ихэвчлэн удамшлын түүхтэй, зарим өвчтөнд загатнах шинж янз бүрээр илэрч болно.

Smith CH, Barker JN (2006) нарын судлаачид “Псориазын эмчилгээний гол аргуудыг тос, чийгшүүлэгч, фото-эмчилгээ, эрхтэн тогтолцооны эмүүд хэмээгээд, тухайн эмчилгээний сонголт нь өвчний хүндрэлийн зэрэг, бие дэх байрлал, өвчтөний нас, өөр төрлийн өвчнөөр давхар оношилогдсон байдлаас хамаардаг” хэмээн тодорхойлжээ.

Орчин үед хэрэглэгдэж буй тосон түрхлэг, ургамлын эмчилгээ, тогтолцооны эмчилгээ болон биологийн идэвхит бэлдмэлүүд нь псориазын шинж тэмдгийг намжаах нөлөө үзүүлдэг боловч төгс эмчилгээний арга бүрэн тогтоогдоогүй байна.

Уламжлалт анагаах ухаанд хайрст үлд өвчний үед дэвтээлгэ заслын ач холбогдлыг олон ном, зохиолд тэмдэглэн үлдээсэн. Тухайлбал, “Эмт таван рашаан”-ы найрлагад Агь (120 г), Зээргэнэ (80 г), Сургар (80 г), Шүгцэр (40 г), Балган бургас (40 г) багтдаг бол зарим номонд Хялгана (120 г), Маалингын бударгана (80 г), Бургил (80 г), Хуш модны навч (40 г), Харгана (40 г)-ыг тэмдэглэжээ.

Эмт таван рашаан (Ганлу)-ы найрлага

Уламжлалт анагаах ухаанд дэвтээлгэ нь монгол анагаах ухааны засал эмчилгээний нэг төрөл бөгөөд анх VIII зуунд Төвөдийн анагаах ухааны сонгодог бүтээл “Дөрвөн үндэс” сударт тэмдэглэгдсэн байдаг. Түүнээс

гадна төвдийн “Дөрвөн үндэс”, “Хөх ном” зэрэг бүтээлүүд Монгол анагаах ухаанд орчуулагдан, баяжигдан хөгжих явцад “Эмт таван рашаан”-ы жорын хэрэглээ өргөжжээ. Сүмбэ хамба Ишбалжирын “Рашааны дусал”, мөн “Монгол эмийн түүвэр” зэрэг сонгодог бүтээлд “Эмт таван рашаан”-ы онол, хэрэглээ, заалт, эсрэг заалт, зохицуулалт болон гол үйлдлийг нарийвчлан тайлбарласан байдаг. Орчин үеийн бүтээлүүд, тухайлбал “Монгол эм судлалын нэвтэрхий толь. Монгол эмийн боть”-д ч мөн дэлгэрэнгүй тэмдэглэн үлдээсэн.

“Эмт таван рашаан”-ы дэвтээлгэ эмчилгээ нь түүхэн урт хугацаанд уламжлалт анагаах ухааны онол, арга зүйгээр баяжигдан хөгжсөн эмчилгээний нэг төрөл юм. Энэхүү жор нь сургар, арцны навч, балган бургас, зээргэнэ, агь гэсэн таван төрлийн ургамлаас бүрддэг бөгөөд 1:1:2:2:3 харьцаагаар найруулж, тан эмийн хэлбэрт оруулан чанаж хэрэглэдэг.

Орчин үеийн анагаах ухаанд үений хэрлэг, анкилоз, спондилит, бруцеллёз, төрсний дараах “салхи цохиулах” өвчин, арьсны эмгэгүүд, ялангуяа хайрст үлд, мөн мэдрэлийн тал саа, саажилт зэрэгт тус жорыг хэрэглэхэд онцгой нөлөөтэй гэж үздэг. Монголын уламжлалт анагаах ухаанд хайрст үлдийг “хэвийн бус шар ус, хий давамгайлсан өвчин”-ий ангилалд багтаадаг бөгөөд монгол эмийн дэвтээлгэ нь хөлөргөх, үрэвслийг дарах, өвдөлт намдаах, шар ус тэгшитгэх, цусны эргэлтийг сайжруулах, судал нээх зэрэг олон үйлдэлтэй. Иймд “Эмт таван рашаан”-ы жор нь хайрст үлдийн дэвтээлгэ засалд оновчтой, үр дүнтэй эмчилгээний арга болдог.

Эмт таван рашаан (Ганлу)-ы найрлагын дэлгэрүүлсэн тайлбар:

1. Сургар

- Амт, чанар: Амтлаг, үл мэдэг гашуун, бүлээн чанартай.
- Үйлдэл: Хүйтэн хийг хөөх, цусны эргэлт

болон түүний хямралыг тэгшитгэх, өвдөлт намдаах.

- Идэвхтэй найрлага: Сапонин, полисахарид, флавоноид, тос, дэгдэмхий тос.
- Фармакологийн үйлдэл: Флавоноид нь түрүү булчирхайн томролын эсрэг, үрэвслийн эсрэг, өвдөлт намдаах нөлөөтэй.

2. Арцны навч (Төвд нэр: Шүгцэр)

- Амт, чанар: Амтлаг, чийглэг; сэрүүн, хөнгөн чанартай.
- Үйлдэл: Бөөрний халууныг бууруулах, шар ус хатаах.
- Идэвхтэй найрлага: Флавоноид, фенилпропаноидын гликозид, терпеноид, лигнан, кумарин.
- Фармакологийн үйлдэл: Үрэвсэл дарах, хавдрын эсрэг, вирусын эсрэг, элэг хамгаалах, дархлаа дэмжих, мэдрэлийн тогтолцоо хамгаалах, антиоксидант үйлдэлтэй.

3. Балган бургас (Төвд нэр: Онбу)

- Амт, чанар: Халуун амттай, амтлаг; сэрүүн, хүнд, хатуу чанартай.
- Үйлдэл: Халуун бууруулах, хор тайлах, шар ус хатаах.
- Идэвхтэй найрлага: Флавоноид, тритерпеноид, галлын хүчил, фенолын хүчил, лигнан.
- Фармакологийн үйлдэл: Бактерийн эсрэг, үрэвсэл дарах, өвдөлт намдаах, үе мөчний үрэвслийн эсрэг, эсийн дархлаа сайжруулах, ядралт бууруулах, элэг хамгаалах.

4. Зээргэнэ

- Амт, чанар: Үл мэдэг гашуун, хуурай; сэрүүн чанартай.
- Үйлдэл: Халуун бууруулах, цусны “хорхой” хөөх, хөлс ялгаруулах, хаван буулгах, өвдөлт намдаах.
- Идэвхтэй найрлага: Эфедриний бүлгийн

алкалоид, дэгдэмхий тос, имидазолын уламжлал.

- Фармакологийн үйлдэл: Халуун бууруулах, судас тэлэх, багтраа намжаах, даралт зохицуулах, төв мэдрэлийн тогтолцоог идэвхжүүлэх.

5. Агь

- Амт, чанар: Ялимгүй гашуун, сэрүүн чанартай.
- Үйлдэл: Цусны эргэлт сайжруулах, ус хатаах, чийг ихсэхийг сарниулах.
- Идэвхтэй найрлага: Сесквитерпен лактон, флавоноид, фенилпропаноидын нэгдлүүд.
- Фармакологийн үйлдэл: Хавдрын эсрэг, антиоксидант, бүлэгнэлт сайжруулах.

Эдгээр таван ургамлын найрлагыг зөв харьцаагаар найруулж, тан эмийн хэлбэрт оруулан чанаж хэрэглэснээр “Эмт таван рашаан”-ы дэвтээлгэ засал нь өвдөлт намдаах, үрэвслийг дарах, шар ус тэгшитгэх, цусны эргэлтийг сайжруулах зэрэг олон талын эмчилгээний үйлдэл үзүүлдэг.

“Эмт таван рашаан”-ы дэвтээлгэ

заслын арга

1. Эмийн найрлагыг нэхмэл бус уутанд хийж, амыг нь сайтар бооно.
2. Уутыг тан буцалгагч төхөөрөмжид байрлуулж, зааврын дагуу буцалгана.
3. Дэвтээлгийн ванн (модон ванн ашиглахыг санал болгоно)-ыг бэлтгэж, дотор нь ууттай найрлагыг байрлуулна.
4. Рашааныг чанаж, тохирох хэмжээнд хөргөсний дараа дээр нь бүлээсгэсэн усыг хийнэ.
5. Усны температур нь улирлын нөхцөл, өвчтөний биеийн онцлогоос хамааран ойролцоогоор 40°C байна.
6. Усны түвшин цээжнээс дээш гарахгүй байхыг анхаарна.
7. Дэвтээлгэ заслын нэг удаагийн

үргэлжлэх хугацаа 20 минут бөгөөд хэтрүүлж сунгахгүй.

8. Эмчилгээний явцад өвчтөний биеийн байдлыг тогтмол хянаж, усны халууныг тогтмол байлгах хэрэгтэй.
9. Эмчилгээ дууссаны дараа бүлээн усаар биеийг зайлуулж, арьсыг хуурайшуулан арчиж, өрөөнд тайван амрахыг зөвлөнө.
10. Дэвтээлгэ заслын эмчилгээг өдөрт нэг удаа, долоо хоногт 4 удаа хийх байдлаар хэрэглэхийг санал болгоно.

Дэвтээлгэ заслын үйлдлийн механизм

“Эмт таван рашаан”-ы найрлагад орсон таван ургамлын идэвхтэй бодисууд нь дэвтээлгэ заслын явцад арьс болон салстын гадаргуугаас шимэгдэн, дараах үйлдлийг гүйцэтгэдэг.

- Судасыг тэлж, цусны эргэлтийг сайжруулах.
- Арьсны эдийг нөхөн төлжүүлж, тэжээлээр хангах.
- Дархлааны тогтолцоог зохицуулах.
- Нян болон вирусын үржлийг дарангуйлах.
- Үрэвслийн үйл явцыг бууруулж, эмчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх.

Эдгээр биологийн идэвхит бодисуудын нэгдэл нь дэвтээлгэ заслын олон талт үйлдлийг бий болгож, өвчтөнд эмчилгээний оновчтой үр дүн үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Засал эмчилгээнд явцад баримтлах дэглэм

- Ваннаас гарсны дараа арьсыг хурдан хуурайшуулж, өвчтөнийг хувцаслуулсны дараа богино хугацаанд амрааж, дараагийн үйлдэлд бэлтгэнэ.
- Ванны явцад өрөөний температур, усны хэм, усны түвшинг тогтмол тохируулан хянаж байх шаардлагатай.

Эмчилгээний өмнөх зөвлөмжүүд:

1. Өвчтөнд дэвтээлгэ заслын үйл явц, анхаарах зүйлс, илэрч болох сөрөг болон гаж урвалын талаар нарийвчлан

тайлбарлан, зөвшөөрсөн нөхцөлд эмчилгээнд оруулна.

Эмчилгээний явцад анхаарах зүйлс:

Сөрөг урвал илрэх магадлалтай тул эмч болон сувилагч нь өвчтөний биеийн байдлыг тасралтгүй ажиглах. Сөрөг буюу гаж нөлөө илэрсэн тохиолдолд эмчилгээг зогсоож, авах арга хэмжээ болон цаашид үргэлжлүүлэх эсэх талаар эмч, сувилагч хамтран шийдвэр гаргана.

Хайрст үлд өвчний үед өгөх эрүүл мэндийн зөвлөгөө

Хайрст үлд нь удаан, архаг явцтай, дахилт ихтэй өвчин бөгөөд өвчтөнд сэтгэлзүйн дарамт, түгшүүр, уур бухимдал, нийгмээс зайлсхийх хандлага, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах зэрэг сөрөг өөрчлөлт үүсгэдэг. Эдгээр нь өвчнийг дахих, хүндэрч даамжрах гол хүчин зүйл болдог тул эмчилгээний туршид өвчтөнтэй тогтмол харилцаж, эерэг сэтгэлзүй, тайван хандлага бий болгоход анхаарах шаардлагатай.

Арьс арчилгааны зөвлөгөө:

1. Үлдний хайрс тогтмол гуужиж унадаг тул хувцсыг тогтмол сольж, ариун цэвэр сахих.
2. Арьс загатнах үед гэмтлийг нэмэгдүүлэхгүйн тулд маажихгүй байхыг зөвлөх.

Идээ, ундааны зөвлөгөө:

- Ихэвчлэн тослог багатай, цагаан хоол хүнс, уураг, амин дэмээр баялаг хүнс хэрэглэх.
- Хурц, халуун, ногоо, харшил өдөөгч чихэр, тодорхой жимс зэрэг хүнснээс аль болох зайлсхийх.
- Эмчилгээний хугацаанд өтгөн цай, кофе, архи, хийжүүлсэн ундаа хэрэглэхгүй, тамхи татахгүй байхыг эрхэмлэх.

Дүн шинжилгээ, таамаглал

“Хайрст үлд” өвчний чиглэлээр тулгамдаж буй асуудлууд:

Хайрст үлд нь арьсны эсүүдийн хэвийн бус өсөлт, үрэвслийн процесс дээр суурилсан архаг явцтай нийгмийн өвчин юм. Хэвийн үед арьсны эсийн гуужилт, нөхөн төлжих үйл явц ойролцоогоор 28 хоногт явагддаг бол псориазтай хүмүүст 3–4 хоног тутамд эсүүд гуужиж, богино хугацаанд шинэчлэгддэг тул улайж, хайрсжиж, тууралт үүсэх замаар “улаан-хөх толбо”-ны давхарга бий болдог.

Хайрст үлдийг халдвар гэж үзэхээс илүү дархлааны систем, цитокиний алдагдал, эсийн нөхөн төлжлийн хэт хурдтай холбон тайлбарладаг. Удаан хугацааны стресс, удамшил, зохицоогүй амьдралын хэв маяг, орчны сөрөг нөлөөллүүд өвчнийг даамжруулдаг болохыг судалгаагаар тогтоосон. Энэхүү өвчин нь зөвхөн арьс дээр түр зуурын тууралт, хайрс үүсгэхээс гадна хумс, үе мөч, үс, биеийн олон хэсгийг хамарч, даамжирдаг онцлогтой.

ЭМС-ын 2020 оны 06-р сарын 30-ны өдрийн А/360 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан “Арьс, үс, хумсны мөөгөнцөрт өвчний оношилгоо, эмчилгээний заавар”-т өвчний кодыг олон улсын 10-р ангилал В35-д хамруулсан. Тус ангилалд сахал ба хуйхны үлд, хумсны үлд, гар, сарвууны үлд, тавхайн үлд, биеийн арьсны үлд, хайрст үлд, цавины үлд, арьсны бусад үлдүүд багтдаг.

Хайрст үлд өвчний эмчилгээнд “Эмт таван рашаан”-ны дэвтээлгэ заслыг хэрэглэх давуу талуудыг дурдвал, байгалийн гаралтай эрдэс, рашааны найрлагатай бөгөөд Хайрст үлд өвчний үед арьсны үрэвсэл, загатнаа, хуурайшлыг багасгах, арьсны хамгаалалтын давхаргыг нөхөн сэргээх ач холбогдолтой юм.

Энэхүү засал нь:

- Химийн бус, байгалийн гаралтай тул арьсанд хоргүй арга болно.
- Мөн арьсны өвдөлт, улайлт, загатнааг богино хугацаанд бууруулна.

- Арьсыг чийгшүүлж, нөхөн сэргээх нөлөөтэй.
- Дээр дурдсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ба дахилтыг бууруулна.

Иймд Хайрст үлд өвчний эмчилгээнд “Эмт таван рашаан”-ны дэвтээлгэ заслыг аюулгүй, үр дүнтэй, байгальд ээлтэй арга гэж үздэг.

“Эмт таван рашаан”-ы дэвтээлгийг хайрст үлдийн эмнэлзүйн практикт хэрэглэхэд арьсны гэмтлийн үед илрэх шинж тэмдэг, зовуурийг багасган, дахилтаас сэргийлж буй байдал нь түүхий эд, жорын найрлагын үйлдлийн механизмаас гадна уламжлалт анагаах ухааны туршлагатай салшгүй холбоотой юм.

Цаашид эмнэлзүйд нэвтрүүлэх, хэрэглээг нь таниулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөтгөхөд үр дүнгээ үзүүлэх боломжтой.

НОМ ЗҮЙ

1. Лувсанчоймбол. (1999) Жэдүйниннор. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, Хөх хот, /монгол орчуулга/.
2. Н.Оюунцэцэг, Д.Цэнд-Аюуш, Н.Төмөрбаатар, Т.Алимаа. (2012). Монгол анагаах ухааны засал. Мөнхийн үсэг ХХК.
3. Арьс , үс, хумсны мөөгөнцөрт өвчний оношилгоо, эмчилгээний заавар. ЭМС-ын 2020 оны 06-р сарын 30-ны өдрийн А/360 тоот тушаалын 1-р хавсралт
4. Parisi R, Symmons DP, Griffiths CE, Ashcroft DM (2013). Identification and Management of Psoriasis and Associated Comorbidity (IMPACT) project team. Global epidemiology of psoriasis: a systematic review of incidence and prevalence. J Invest Dermatol. 133:377–385.
5. Griffiths CE, Barker JN. Pathogenesis and clinical features of psoriasis. Lancet. 2007;370:263–271.
6. Rapp SR, Feldman SR, Exum ML, Fleischer AB Jr., Reboussin DM. (1999). Psoriasis causes as much disability as other major medical diseases. J Am Acad Dermatol. 1999; 41: 401–407.
7. Smith CH, Barker J N. Psoriasis and its management. BMJ. 2006; 333:380–384.
8. Huerta C, Rivero E, Garcia Rodriguez LA. Incidence and risk factors for psoriasis in the general population. Arch Dermatol. 2007;143:1559–1565.
9. У.Лигaa. (2015). Монгол орны эмийн ургамлыг өрнө, дорнын анагаах ухаанд хэрэглэхүй. II хэвлэл
10. 3.Мэндсайхан, 3.Ариунаа. (2016). Эмт ургамал. Боть 1, 2. Мөнхийн үсэг.
11. Арьс ба бэлгийн замын өвчин судлал (8-р хэвлэл, 2013, редактор Жан Сюэжүн)
12. Zeyu Chen, Yu Gong болон Yuling Shi (2017). Novel Biologic Agents Targeting Interleukin-23 and Interleukin-17 for Moderate-to-Severe Psoriasis. Clinical Drug Investigation. Oct; 37(10):891-899. doi: 10.1007/s40261-017-0550-z.